

ХЯТАДЫН ӨНӨӨ БА ИРЭЭДҮЙ

Х.Эрдэнэчулуун¹, Ю.Отгонжаргал²

Хятад улсын хөгжлийн ирээдүйг тодорхойлохын тулд өнөөгийн байдал дээр тогтож, тулгарч буй асуудлыг авч үзэх ёстой. Өнөө үед Хятад улсын өмнө тулгарч буй асуудалд хүн амын хэт өсөлт, ажилгүйдлээс үүдсэн хямрал, байгаль орчны эвдрэл сүйрэл, тэгш бус байдал, ёс суртахууны доройтол, авилга, улс төрийн тогтвортой байдал зэргийг оруулж болно.

Хүн амын хэт өсөлт

Энэ бүх асуудлын үндэс нь хүн амын хэт өсөлт юм. Хятад улс өргөн уудам нутаг дэвсгэртэй хэдий ч ихээхэн хэсэг нь уул нуруу, говь цөл байдаг. 2010 оны эцсээр Хятадын хүн ам 1.341 саяд хүрсэн тухай Хятадын Үндэсний Хүн Амын Статистикийн Газраас энэ оны 2 дугаар сарын 28-нд мэдээлсэн. Хятад улсын хүн ам 2009 онд 1.335 сая, харин 2008 онд 1.328 сая байжээ. Хятадын хүн ам жил тутам 8 сая орчмоор нэмэгдэж, 2033 он гэхэд өсөлтийн оргилдоо хүрч 1 тэрбум 500 саяд хүрнэ гэж Хятадын Хүн ам болон төлөвлөгөөт төрөлтийн үндэсний хорооны дарга хатагтай Ли Бинг хэлсэн байна. Бээжинд болсон “Өөрчлөлт шинэчлэлийн бодлогын хэрэгжилт болон хүн амын хөгжил” чуулга уулзалт дээр тэрээр хэлэхдээ: “Төрөлтийн хэмжээг бага бөгөөд тогтвортой байлгаж хүн амын тоог тогтоон барих асуудал нь Хятадын өнөөгийн хүн ам болон төлөвлөгөөт төрөлтийн тэргүүн зэргийн чухал ажил хэвээр байх болно” гэжээ.

Тус улсад төрөлт ихээхэн бага үзүүлэлттэй байгаа нь хүн амын өсөлт харьцангуй буурч, наслалтыг ихээхэн нэмэгдүүлж байгаа юм. Хүн ам зүйн энэхүү өөрчлөлт нь Хятадын эдийн засагт ихээхэн нөлөөлж байна. НҮБ-ын мэдээлснээр Хятадын 15-аас доош насны хүүхдийн тоо 1976 онд түүхэн дээд хэмжээ буюу 360 орчим сая байжээ. Харин 2010 оны хүн амын тооллогоор тус улсын 0-14 насны хүүхдийн тоо 222 сая орчим болжээ. Хятадын хүн амын 16.6 хувь нь 14 хүртэлх насныхан болж байгаа нь арван жилийн өмнөхтэй харьцуулахад 6.29 хувиар буурсан үзүүлэлт болж байна. Өнгөрсөн 35 жилийн хугацаанд Хятадын бага насны хүүхдийн тоо 138 саяар буурсан бол ирэх 35 жилд энэ тоо улам багасч 80 сая болно гэж НҮБ-аас мэдээлжээ.

Хятад улс “Нэг өрх - нэг хүүхэд” бодлого хэрэгжүүлэн хүн амын өсөлтөө зохицуулж байгаа бөгөөд энэ нь тус улсын эдийн засагт нааштай нөлөө үзүүлж байгаа юм. Хүүхдүүд дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлтөд хувь нэмэр болохгүй харин зарлага хэмээн үздэг байна. Тиймээс Хятадын одоогийн хүн амын наслалтын бүтэц хамгийн тохиромжтой үедээ байгаа ч хамгийн сайн ажилладаг, хамгийн бүтээмж өндөртэй ажилладаг насныхан хөгширснөөр дараагийн асуудал нүүрлэх билээ.

¹ Гаалийн Ерөнхий Газрын зөвлөх, доктор (Ph.D), профессор

² МУИС-ийн ЭЗС-ийн докторант

Өсөлтийн хурд удааширч, хөгшин хүмүүсийн эзлэх хувь нэмэгдэж, 60-аас дээш насны хятадууд хүн амын 13.3 хувийг эзэлж байгаа нь 2000 оныхоос гурван хувиар илүү үзүүлэлт юм. Төрөлтийг хянах бодлогын улмаас төрөлт нэг хувиас бага болжээ.

Хятадын хүн амын тоо 2040 он хүртэл 135 саяар өсөх ч дараагаар нь төрөлт багасч эхлэх гэнэ. Улмаар хүн амын тоо 1.5 тэрбум гэсэн тооноос давж гарахгүй тухай Хятадын хүн ам судлалын тэргүүн Цэнь Вэйпинь мэдээлснийг Синхуа агентлаг дамжуулж байна. Өнөөдөр Хятадын хүн амын төрөлтийн коэффициент 1.6-1.8 байгаа бөгөөд 2040 он гэхэд хүн амын тоо 1.47 тэрбумд хүрэх боловч дараа нь эрс буурч 2050 он гэхэд 1.45 тэрбум болно гэж тэрээр Бээжинд болсон Дэлхийн хүн амын өсөлтийн талаарх олон улсын зөвлөлгөөн дээр хийсэн тайландаа дурджээ. Хүн амын 51.27 хувь нь эрэгтэйчүүд, 48.73 хувь нь эмэгтэйчүүд аж. Хүн амын тооллогын урьдчилсан дүнг 2009 оны байдалтай харьцуулбал тариачин 5.4 хувиар, хөдөөнөөс хотод шилжин ирж ажиллагсад 5.5 хувиар тус тус өсч 2000 онд хүн амын 36 хувь нь хотод амьдарч байсан бол эдүгээ энэ үзүүлэлт 50 хувь буюу 665.5 саяд хүрчээ.

Хятадын нийслэл Бээжин хотын хүн ам сүүлийн 10 жилд 6 саяар өсч 19.9 сая болсон тухай тус хотын эрх баригчид мэдээлжээ. Өнгөрсөн хугацаанд тус хотын хүн ам жилд дунджаар 3.8 хувиар өссөн байна. Энэ нь үндсэндээ Хятадын бусад бүс нутгаас шилжин ирж суурьшигчдын тоо нэмэгдсэнтэй холбоотой юм. Одоогийн байдлаар Бээжингийн гурван оршин суугч тутмын нэг нь шилжин ирэгсэд ажээ.

Хөдөлмөрийн насныхан хүн амын ихэнх байх нь татварын орлогыг нэмэгдүүлэн үүгээр нь өсвөр болон өндөр настай иргэддээ үр ашгийг нь хүртээх бодлого хэрэгжүүлдэг. Харин одоо Хятад улс эргэлтийн цаг дээрээ иржээ. Хөдөлмөрийн насныхны эзлэх хувийн жин буурч байгаа нь хүн амын бодлогоо өөрчлөх цаг болсныг харуулж байна.

Харин хүн амын амьжиргааны түвшингээс доогуур буюу ядуурлын түвшинд буй хүн амын тоо 2009 онтой харьцуулахад 9.9 саяар буурсан байна.

Ажилгүйдлээс үүдсэн хямрал

2000-2010 онд Хятадын хөдөлмөрийн чадвартай хүн амын тоо 70 саяар нэмэгдсэн. 2009 оны байдлаар Хятадын нийт ажиллах хүч 779.9 сая байна. Тиймээс хөдөлмөрийн зах зээл жил бүр 7 сая гаруй ажлын байр бий болгох ёстой бөгөөд 5 жилийн дараа энэ тоо Германы улсын ажлын байрны тоотой тэнцэх юм. Үүний дээр улсын секторт цомхотгол үргэлжлэх нөхцөлд 5 сая шинэ ажлын байрны хэрэгцээ гарна. Асуудал үүгээр дуусахгүй. Тариачны нэг өрхөд дөнгөж 0.55 га талбай ногдож буйгаас ажил эрхлэлт дэндүү өчүүхэн учир 2010 он хүртэл 75 сая орчим тариачин ажилгүй болсон байна. Үүнээс 20 сая хүн хот суурин газар бараадах боловч 50 сая хүн хөдөөд ажилгүй үлдэх юм. Мао Цзедуны үед гарсан Өрхийн бүртгэлийн хууль хүмүүсийг төрсөн газартай нь хадаж өгчээ. Энэ хуулиар хөдөөгийн хүн ам хөдөө нутагтаа түгжигдмэл хадаастай байв. 1984-1986 онд шинээр байгуулагдаж байсан хөдөө орон нутаг дахь аж үйлдвэр, үйлчилгээний газрууд ажлын байр их хэмжээгээр бий болгож байсан. Энэ үед ч хөдөөд бүх хүнийг ажилтай болгож чадаагүй юм. Гэвч 1996 онд энэ төгсгөл болж 1997-2000 онд хөдөө орон нутаг дахь ажилгүйдэл эрс өсчээ. Хотод шилжин ирэгсдийн дийлэнх нь барилга, үйлдвэр, гуанз хоолны газар зэрэг газар албан бусаар ажиллах, зарим нь гудамж талбай цэвэрлэх, эмэгтэйчүүд нь айлд зарагдах зэргээр хотынхны тоож хийдэггүй ажлыг өчүүхэн бага цалинтайгаар, нийгмийн ямар ч хамгаалалтгүй, үр хүүхэд нь сургуульгүй, хөөгдөх вий гэсэн байнгын түгшүүр дунд амьдардаг байна. Шилжин

ирэгсэд нэмэгдэхийн хэрээр хотынхон ажлын байраа алдсаар байгаа юм. Эдгээр нь 1996 оноос хойш жилд 5-6 саяар нэмэгдэж байна. Тэдгээрийн тал хувь нь нийгмийн халамж болох сарын 150 юань авдаг боловч эл мөнгө нь юунд ч хүрэлцэхгүй юм. Энэ мөнгө олгогдохгүй байх тохиолдол ч олонтаа.

Хятадын Төрийн Зөвлөлийн Ерөнхий сайд Вэнь Зяобао шинэ статистик мэдээтэй холбогдуулан Засгийн газраас санхүүгийн хямралыг намжаах үүднээс 585 тэрбум юанийн төлөвлөгөөг зарлаж магадгүй талаар мэдээлсэн байна. 2008 оны 12 дугаар сарын сүүлчээр гаргасан мэдээгээр 2008 оны 3 дугаар улиралд дор хаяж 10 сая хүн ажлаа алдана гэсэн тооцоо гаргаж байсан. Гэтэл тооцоолсон хэмжээнээс хэт их ажилгүйдэл бий болж байгаа нь Хятадын Засгийн газрын анхаарлыг татаж эхэлсэн. Хятадын засгийн газар нийгэмд таагүй байдал үүсгэхгүй байх үүднээс ажилгүйдэл, нийгмийн нөхцөл байдлын талаар мэдээлэл огт хийхгүй байсаар ирсэн юм. Харин одоо Засгийн газар нийгэмд эмх замбараагүй байдал бий болж магадгүй гэдгийг ойлгосон тул арга хэмжээ авахаар шийдсэн бололтой. 2009 он санхүүгийн хувьд хөдөө тосгон руу хөгжлийн хөтөлбөр, төсөл явуулж магадгүй.

Хятадын ажилгүйдлийн түвшин албан ёсны мэдээгээр 4.1 хувь бөгөөд албан бус мэдээгээр 12-14 хувьтай байна. Албан ёсны статистик тоонд компани буюу үйлдвэрээсээ “чөлөөлөгдсөн” хэдий ч орон сууцандаа цаашид амьдрах эрхтэй байж, үйлдвэр, компаниасаа мөн л өчүүхэн хэмжээний мөнгөн тусламж авах боловч мөн л төлөгдөхгүй байх нь цөөнгүй байдаг ажиллагсдыг оруулж тооцдоггүй. Мөн уг статистик мэдээнд хөдөөд амьдардаг гэх ч мөн л ажил эрж хэсүүчлэн явагсад, мөн хэзээ ч ажлын байртай болж үзээгүй залуучуудыг хамруулдаггүй. Хотуудад ажилгүйдлийн төвшин 20 хувьд хүрч буй гэж бие даасан ажиглагчид тооцоолж байна. Хувийн сектор түргэн хөгжиж буй Шанхай, Бээжин, Кантонд байдал нааштай байгаа бөгөөд харин саяхныг хүртэл дан улсын үйлдвэрүүдтэй байссан умрын болон өрнийн хотуудад байдал муухан байна.

Судлаачдын тооцоолсноор Хятадад дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлт нэг хувиар буурахад 8 сая хүн ажилгүй болдог гэж үздэг бөгөөд энэ тооцоогоор даруй 24 сая хүн ажилгүйдэлд нэрвэгдээд байна. Дэлхийн банкны “2009 оны дэлхийн эдийн засгийн прогнозоос үзвэл 2007 онд Хятадын ДНБ-ий өсөлт 11.9 хувь байсан бол 2008 оны эхний гурван улирлын байдлаар 9 хувь болж буурсан бөгөөд 2009 онд 7.5 хувь болж буурах төлөв байна.

Өнгөрсөн жил Хятадын эдийн засаг дэлхийн даяар 14 сая ажлын байр бий болгосон гэж БНХАУ-ын дарга Ху Жиньтао АНУ-д энэ оны эхээр хийсэн айлчлалынхаа үеэр мэдэгдсэн юм. Хятадын өөрчлөлт, шинэчлэлийн үндэсний хорооны орлогч дарга Жан Шаочян хэлэхдээ “2002-2008 онд Хятадын гадаад хөрөнгө оруулалтын хэмжээ 2.7-56 тэрбум ам.доллар болж жилийн дундаж өсөлт 66 хувь болтлоо өссөн” гэж мэдээлжээ. Америкийн конгрессын гишүүд “Хятадын бодлого нь АНУ-д ажилгүйдлийг нэмэгдүүлж байна” хэмээн үзэж байна. Гэтэл Ху ЖиньТао дарга Хятадын буянаар америкийн хэрэглэгчид хямд бөгөөд чанартай бараа худалдан авч 600 тэрбум ам.доллар хэмнэж байна гэсэн юм. Хятадын Төрийн Зөвлөлийн Ерөнхий сайдын орлогч Ли Кэцянь мэдэгдэхдээ Хятадын импорт 2011 онд 1.5 их наяд ам.доллараар нэмэгдэж байгаад анхаарлаа хандуулахыг хүссэн байна. Импортын барааны эрэлтийг нэмэгдүүлснээр Хятад улс бусад орнуудын үйлдвэрлэлийг дэмжиж байна гэж тэрээр онцолжээ.

Улам өссөөр байгаа хүн амаа ажилтай байлгахын тулд Хятад улс юу хийх хэрэгтэй вэ? Энэ бол хамгийн чухал суурь асуудал юм. Хятад улсын эдийн засгийн өндөр хурдацтай өсөлт

шинээр ажлын байр шинээр бий болгох чадвараар сул байна. Хэрвээ 1986-1990 онд дотоодын нийт бүтээгдэхүүний нэг хувийн өсөлт 1.51 сая ажлын байр шинээр бий болгож байсан бол 1991-1995 онд энэ хувь 0.85 болтлоо буурчээ. Эдийн засгийн өсөлт хэдий өндөр хувьтай байлаа ч энэ нь шинээр бий болж буй ажиллах хүчний цэвэр өсөлтийг л шингээхээс бус одоо байгаа ажилгүйчүүдийг багасгаж чадахгүй байгаа юм.

Байгаль орчны эвдрэл сүйрэл

Хүн амын хэт өсөлттэй нягт холбоотой хоёрдахь үндсэн асуудал бол байгаль орчны эвдрэл сүйрэл юм. Хятадын хотууд аж үйлдвэр, автомашины утаанд багтарч байна. Хөдөө аж ахуйн эдэлбэр газрын хөрс эвдэрч, цөлжиж байна. Гол мөрөн, нуур цөөрөм бохирдож хордож байна. Шар мөрний ус олон сараар тасарч байна. Усны дутагдал хамгийн том асуудал болж байна. Усны хэрэгцээнийхээ гуравны хоёрыг гүний усаар хангадаг Бээжинд 1999 онд усны түвшин 3.5 метрээр доошилжээ. Дорнод болон Зүүн Хойд зүгийн тал нутагт гүний усанд хүрэхийн тулд 60 метр хүртэл гүн өрөмдөх болжээ. Усны өртөг өндөр болж байгаа тул үр тарианы үйлдвэрлэл ашиггүй болж байна.

Эдийн засгаа цэгцэлж байгаа орнуудад экологийн гэх энэ шинэ асуудал зайлшгүй урган гардаг. Үүний нэг тод томруун жишээ бол Хятад улс болж байгаа юм. АНУ-д мод огтлох явдалтай тэмцэхийн тулд удирдагчид нь том ажил өрнүүлж байсан. Түүнтэй нэгэн Хятад улсын хувьд байгаль орчны бохирдлын асуудал нь үндэсний аюулгүй байдалд аюул учруулахуйц хэмжээнд хүрчээ. Тус улсын Үйлдвэр, мэдээллийн технологийн яамны мэдээлснээр 2010 оны 9 дүгээр сарын 30-ны дотор 2087 ган, цемент болон эрчим хүчний үйлдвэрийн үйл ажиллагааг зогсоохоор болсон байна. 2009 оны зун Хятадын Төрийн Зөвлөлийн Ерөнхий сайд Вэн Зяобао “Гангийн үйлдвэрлэлийг бууруулах замаар эрчим хүчний хэрэглээг багасгана” гэж мэдэгдэж байсан юм.

Хятадын Үндэсний хөгжил, шинэтгэлийн хорооноос гаргасан мэдэгдэлд дурдсанаар: “Тус улсад сүүлийн жилүүдэд эрчим хүчний хэрэглээ эрс нэмэгдэх болсон. Энэ нь хорт утаа, хаягдлаараа байгаль орчныг бохирдуулж буй хүнд үйлдвэрүүдтэй холбоотой” ажээ. 2005-2009 онд эрчим хүчний хэрэглээ 20 хувиар өссөн мэдээ байгаа юм. Үүнээс болж Бээжин зэрэг томоохон хотуудад хүлэмжийн хий ихэссэн. Хятад улс нь газрын тос, нүүрсний импортоо нэмэгдүүлэх болсон нь эцэстээ эрчим хүчний бодлогоо өөрчлөхөд хүргэж болзошгүй байна. Олон улсын эрчим хүчний агентлагаас өнгөрсөн сард гаргарсан мэдэгдэлд дурдсанаар Хятад улс эрчим хүчний хэрэглээгээрээ АНУ-ыг ардаа орхиж дэлхийд тэргүүлэх болсон. Энэ ч утгаараа, Хятадад хүлэмжийн хийн хэмжээ огцом нэмэгджээ. Тиймээс уг асуудлыг шийдвэрлэхийн тулд БНХАУ-ын дарга Ху Жинтао 2020 он гэхэд нүүрс хүчлийн хийн ялгаруулалтыг 40-45 хувиар бууруулна гэсэн зорилт тавьсан. Хүлэмжийн хийн ялгаруулалт нэмэгдэхэд хүнд үйлдвэрүүд төдийгүй жирийн иргэд ч нөлөөлж байна. Сүүлийн жилүүдэд Хятадад дундаж орлоготнуудын автомашин худалдан авалт нэмэгдсэн нь нүүрстөрөгчийн ялгаруулалт нэмэгдэхэд нөлөөлж байна.

Хятадад сүүлийн жилүүдэд нүүрсний жижиг уурхайнуудаа хаах нь ч нэмэгдсэн. Хятад улс 2009 оны эцэс гэхэд нийт нүүрсний уурхайн 80 хувийг бүрдүүлдэг жижиг уурхайг 10 мянгаас цөөн болгосон. Ингэснээр, наад зах нь 7000 орчим уурхай хаагдах юм. Жижиг уурхайнуудын хувьд чанар муутай нүүрс гаргадаг, ашиг орлого нэгдүгээрт тавьдаг гэдэг ч хамгийн ноцтой нь байгаль орчны нөхөн сэргээлт хийдэггүй юм. Энэ нь хамгийн их хор уршиг тарьж байгаа юм.

2009 оны эхээр алт олборлолтоор тэргүүлдэг “Зинжин майнинг” групп их хэмжээний хорт

бодис алдсан тухай мэдээлэл цацагдсан. Энэ мэт шалтгааны улмаас Хятадын Засгийн газар үйл ажиллагаа нь байгаль орчны бохирдуулж байгаа компаниудын жагсаалтыг гаргахаар болсон. Ган, цемент, алт, нүүрсний уул уурхайн компани зэрэг 16 төрөл, салбарын компаниуд уг жагсаалтад багтах аж. Энэ талаар Хятадын Байгаль орчны яамнаас мэдээлжээ. “Синхуа” агентлагийн мэдээлснээр, Хятадын эдийн засаг төлөвлөлтийн ахлах мэргэжилтэн Жан Сяокин “Хятад улс 2020 он гэхэд эрчим хүчний хэрэглээгээ 20 хувиар бууруулахын тулд бүх арга хэмжээ авна” гэжээ. Гэвч эдгээр нь байгаль орчны бохирдоло эвдрэлийг зогсоож чадахгүй байна. Ус, газар, агаар нь эдийн засгийн цаашдын өсөлтийг хангахад хүрэлцэхгүй болох аюул заналхийлж байна.

Тэгш бус байдал

Дээр дурдсан хоёр асуудал дээр эдийн засгийн өндөр өсөлтөөс үүдэн гарч ирж буй бас нэг асуудал нь хятадын нийгэм дотор бий болж улам нэмэгдсээр буй тэгш бус байдал, далайн эргийн муж, нутгийн гүний мужуудын хөгжлийн тэгш бус байдал, хот, хөдөөгийн хөгжлийн ялгаа юм. Гэвч өрнийн ажиглагсад Хятадын нийгмийн задралын ярихдаа хэтрүүлэх нь бий. Дотоод мужуудаас цөөнгүй нь өсөлтийн өндөр хувьтай, Төв болон Баруун Хятадын өсөлтийг дэд бүтцийн болон боловсролын хөрөнгө оруулалтын хүчээр урагшлуулах талаар Засгийн газрын хүч чармайлт гаргаж байна. Тэдгээрийн хувьд дотоодын мужууд нь бүтээгдэхүүнээ борлуулах чухал зах зээл, түүнчлэн, хямд ажиллах хүчний нөөц сан болж өгдөг. Үүний дээр хятад хүний зүрх сэтгэлд оршиж байдаг.

Харин хот, хөдөөгийн хөгжлийн ялгаатай нэмэгдэх нь хамаагүй илүү аюултай. Албан ёсны статистик мэдээгээр хөдөөгийн хүн амын цэвэр орлого 1985 онд хотын оршин суугчдын дундаж орлогын 54 хувь болж байсан бол 2000 онд 36 хувь болж буурчээ. Орлогын ялгаа их байгаа нь тариачдыг дургүйцлийг төрүүлж байгаа юм.

Хөгжил тэгш бус байдлыг ямагт дагуулдаг. Зарим нэг нь хурдан баяждаг. Дэн Сяопин энэ үр дагаврыг анхнаас нь ойлгож хүлээн зөвшөөрч байсан. Хятадын хувьд тэгш бус байдал шинэ зүйл, шинэ ойлголт юм. Тэд хэдэн мянган жилийн туршид газар тариалан эрхэлж адил тэгш амьдарч байсан. Ард түмний дээр засаглагч цөөн хүний дархарга эзэн хаан, 20 мянган дээд түшмэл, орон нутгийн эрдэм номтой хүмүүс, газрын эзэн, худалдаачдын жижиг, дунд давхарга байсан. Мао Цзедуны үед бүгд тэгш байх хатуу дэглэм ноёрхож байв. Дэн Сяопиний хувьд зах зээлийн эдийн засгийн шинэчлэлийн үеэс л нийгэм их хурдацтайгаар задарч эхэлжээ. Одоо гурван зуун сая орчим гишүүнтэй дээд давхарга байхын зэрэгцээ мөн л гурван зуун орчим сая хүнийг хамарсан эдийн засгийн өсөлтөөс ерөнхийдөө юу ч хүртээгүй хүмүүсийн давхарга, түүнчлэн одоо улсын үйлдвэрийн шинэчлэлээр ажилгүй болж буй ажилчид мэт шинэчлэлээр хохирсон хүмүүс бий. Нөгөөтэйгүүр Хятад улс 1978 оноос хойш үнэмлэхүй ядуурлыг бараг бүрэн арилгаж чадсан гэдгийг хэлэх хэрэгтэй.

Хятад улсад хэрэглээ бүхэлдээ (абсолют утгаараа) нэмэгдсэн боловч хэрэглээний квот – өрхийн тасвийн орлогод хэрэглээний эзлэх хувь хэмжээ – орлого нэмэгдсэн хэдий ч буурах хандлагатай байна. 2005 онд хятадын нийт өрхийн хэрэглээнд эдийн засгийн чадамжийн 40 хүрэхгүй хувийг зарцуулсан байхад харин 30 орчим хувьтай нь тэнцэхүйц хөрөнгийг банкинд хадгалуулсан байна.

Зах зээлийн эдийн засаг дан ганц өөрийн дотоод эрч хүч, динамик хүчээр өдөөгдөн урагш дэвшин хөгжиж байдаггүй. Түүний бүхий л хэв шинж нь угаасаа эвдэн сүйтгэх чанартай. Зах зээлийн эдийн засагт хөрөнгө оруулалт зайлшгүй шаардлагатай, харин хөрөнгө оруулалт хэрээс хэтэрвэл хэт их бүтээгдэхүүний нийлүүлэлт бий болж зах зээл дүүрч савнаасаа хальж эхэлнэ. Зах зээлийн эдийн засагт хэрэглээ хэрэгтэй, гэхдээ гагцхүү зөвхөн хэрэглээд байж таарахгүй, Зах зээлийн эдийн засагт өрсөлдөөн хэрэгтэй, гэхдээ энэ өрсөлдөөн харгис хэрцгий, бусармаг агаад аюул хөнөөл дагуулна. Энэ бүх “сэтгэлийн хөөрөл, халил”-ыг тогтоон барьж байх хууль, эрх зүйн өргөн хүрээтэй зохицуулалт, тогтолцоо шаардлагатай.

Ёс суртахууны хоосон орон зай

Оюун ухааны хоосрол бол ёс суртахууны хоосрол юм. Хотуудад гэмт хэрэг газар авч байна. Хотынхон ажил эрж хэсүүчлэн явагч хөдөөгийн ажилчдыг буруутгаж буй. Энэ бол шинэ үзэгдэл. Хүмүүс хэдэн мянган жилээр өөрийн төрж өссөн тосгоныхоо хүрээнд л амьдарч ирсэн. Гэтэл одоо энэхүү бат бэх журам задарч байна. Оюуны хоосон орон зай бий болж байна. Олон хүн мөнгөнд шунаж үхэн хатан хөөцөлдөхөөс өөр аргагүй болжээ. ХКН-аас энэ орон зайг эх оронч үзэл, Күнзийн сургаал, аугаа түүхээрээ бахархах үзлээр дүүргэхийг оролдож байна.

Орчин цагийн Хятад гүрний нийгмийн амьдрал, нэгд, асар хурдацтай төлөвшиж буй материаллаг хандлага, хоёрт, шашны сонгодог уламжлалт ойлголтыг үл ойшоох хандлага, гуравт, аль болох их хөрөнгө хуримтлуулах хэм хэмжээ, эрмэлзлэлээр тодорхойлогдож байна. Энэ бүхэн нь эдийн засгийн хөгжлийн хувьд хоцрогдонгүй, ядуу тарчиг улс оронд эдийн засгийг либеральчлах үед ажиглагддаг ердийн үзэгдэл юм. Эдийн засгийн хувьд гэнэт үсрэн дэвшиж байгаа хэдий ч улс төрийн талаар тогтворгүй, төр засаг нь сул дорой улс орнуудад иргэд нь ирээдүй, хэтийн амьдралынхаа талаар итгэл найдвэр сул, төрийн зүгээс нэн ялангуяа боловсрол, эрүүл мэнд, өндөр насны тэтгэвэр, тэтгэмжийн талаар тэдэнд үзүүлэх тусламж дэмжлэгийн тогтолцоо цэгцрээгүй зэргээс үүдэн хөрөнгө чинээ хуримтлуулах, хэмнэх хандлага хүчтэй байдаг.

Чухамхүү эндээс л зах зээлийн эдийн засгийг засч залруулах, үнэт зүйлсийн цогц систем байх ёстой. Энд анхаарах учиртай хоёр хүчин зүйлс байна. Нэгд, нийгмийн өмнө хариуцлага хүлээж, хүлцэнгүй даруу байх тухай шашны сургаал үнэт зүйлс нь ажил хэргийн харилцаанд найдвартай байх итгэл үнэмшлийг төлөвшүүлдэг байх магадлалтай. Энэхүү хүчин зүйл нь зах зээлийн эдийн засгийн тогтолцоонд дөнгөж шинээр дэвшин жор буй орнуудад өндөр ач холбогдолтой. Олон зууны туршид хүчтэй нь хүчгүйгээ дийлж үл итгэх, хардах сэрдэх байдал ноёрхож байсан алибаа улс оронд хүмүүс урт хугацааны үүрэг авч гэрээ хэлэлцээр байгуулахаасаа илүүтэйгээр бусдын эрх ашгийг үл ойшоон аль болох богино хугацаанд их ашиг хонжоо олохыг эрмэлздэг. Үүний дүнд зах зээлд үл итгэх хандлага хүчтэй байдаг. Хоёрт, нийгмийн эв нэгдэл, нягтралыг сургасан шашны сургаал, үнэт зүйлс нь нийгмийг туйлшруулж, тэнцвэргүй тэгш бус байдлыг өөгшүүлэхэд чиглэсэн зах зээлийн хандлагыг тогтон барьж хязгаарлах, засч залруулах чухал ач холбогдолтой. Хятад улсад эдүгээ нийгмийн ийм туйлшрал гүнзгийрч, тэгш бус байдал өндөр хурдацтайгаар газар авч байна. Үйл явцын ийм өрнөлийг эсэргүүцсэн тэмцэл, хөдөлгөөнүүд түүрхэнд даяарчлал, улс хоорондын худалдаа, санхүүгийн харилцаанд улс төрийн ихээнхэн хохирол учруулж, хойш татж байсан байсан нв цөөнгүй. Шашны сургаал, шүтлэгийн ид шид, эсхүл хүлцэнгүй даруу ноомой байдал, итгэл үнэмшлээр хөдөөгийн тарчиг ядуу нийгмээс техник технологи үсрэнгүй хөгжсөн, баян чинээлэг (high tech socety) нийгэмд шилжих ямар ч боломжгүй юм.

Улс төрийн тогтвортой байдал

Нийгмийн анги давхаргуудын хоорондох ба бүс нутгийн хөгжлийн тэнцвэртэй байдал алдагдаж байгаа нь хүн амын дотор тааламжгүй уур амьсгал бий болгож байна. Эрх мэдлийг дур мэдэн хуваарилах, авилга болон бусад асуудал тааламжгүй хандлагыг нэмэгдүүлж байна. Боловсрол ба орлогын өсөлт, төрийн бус байгууллагууд ба интернэт зэрэг нь сөрөг хүчний хөдөлгөөн ба хорлог сүйтгэгчдийн тоо нэмэгдэхэд нөлөөлжээ.

Ийм нөхцөлд Хятадын Төрийн зөвлөлийн Ерөнхий сайд Вэн Зябао эдийн засгийн өөрчлөлттэй дүйцэхүйц улс төрийн өөрчлөлт явуулах ёстой хэмээн уриалах боллоо. Вэн Зябао нэг талаас намаа мэдэгдэхүйц өөрчлөхийг уриалж байгаа мэт боловч үнэн хэрэг дээрээ нам өөрчлөгдөнө гэсэн найдварыг хадгалах замаар хүмүүсийг тайвшруулах гэж байж болно. Улс төрийн өөрчлөлт нь зөвхөн дотоодын хэрэглээг нэмэгдүүлэх төлөвлөгөөг биелүүлээд зогсохгүй нийгмийн тааламжгүй уур амьсгалыг намжаах зорилготой аж. Өөрчлөлт гарцаагүй боловч хяналтаа алдахгүйгээр яаж хийх вэ? гэдэг нь асуудал юм.

Дээрх дурдсан эдийн засаг, нийгэм, улс төрийн асуудлууд нь Хятад болоод олон улсын эдийн засгийн системд явагдаж буй өөрчлөлтийн үр дагавар ажээ. Эдгээр асуудлыг нарийвчлан судалснаар Хятадын эдийн засаг ирэх 5 жилд Америкийн эдийн засгийг гүйцэж чадах уу? гэдэгт хариу өгөх боломжтой болно.